



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/428

Улаанбаатар хот

### Шуурхай штабыг сунган ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 259 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 41, 46 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/477 дугаар захирамж, Засаг даргын зөвлөлийн 19 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан, шинэ коронавируст (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил, хяналт шалгалт явуулахтай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэн дамжуулах, дуудлага, мэдээллийн дагуу ажиллах үүрэг бүхий шуурхай штабыг 2021 оны 10 дугаар сарын 01-нээс 2021 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал сунгаж ажиллуулсугай.

2. Шуурхай штабын ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагаанд шаардагдах 8,773,000 (найман сая долоон зуун далан гурван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч Б.Хонгорзулд зөвшөөрсүгэй.

4. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалт, үүссэн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн Улсын Онцгой комисстой зөвшилцөн иргэдийн хөдөлгөөн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, хязгаарыг тогтоож, шаардлагатай тохиолдолд хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шилжүүлж, халдвар хамгааллыг мөрдүүлж ажиллах; хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс (Б.Идэрбат)-т, Цагдаагийн газар (М.Батсайхан)-т тус тус даалгасугай.

5. Шуурхай штабт ажиллах жижүүрийн бүрэлдэхүүнийг 24 цагаар үүрэг гүйцэтгэхээр томилон, шуурхай штабтай хамтран ажиллаж, өдөр тутмын явцын мэдээ, мэдээллийг штабын 70120318 дугаарын утсанд 14:00, 20:00 цагуудад, нэгдсэн мэдээг 08:00 цагт өгч, өгөгдсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-д даалгасугай.

6. Дүүргийн нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалтаар ажиллаж байгаа бүрэлдэхүүн эргүүлийн нэгдсэн мэдээг 18:00 цагт Шуурхай штабт өгч ажиллахыг харьяа хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шуурхай штабыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга бөгөөд Онцгой комиссын орлогч дарга (Ж.Наранмандах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын  
2021 оны 10 дүгээр сарын 15-ны өдрийн  
А/428 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт


ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2021 оны 09 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Зардлын төсөв	Нэг бүрийн үнэ	Хоног /тоо ширхэг/	Нийт
1	Хоол	20.000	31x9	5.580.000
2	Шатахуун /хоногт 1 автомашин/	33.000	31	1.023.000
3	Цэвэр ус баллонтой	5.000	10	50.000
4	Бичгийн цаас	12.000	5	60.000
5	Принтерийн хор /жижиг/	65000	4	260.000
6	Сайн дурын эмч /Шуурхай штаб/	3	600.000	1.800.000
	Бүгд			8,773,000

Баянгол дүүргийн Засаг даргын  
2021 оны 10. дүгээр сарын 15-ны өдрийн  
А/428.. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



## ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь Баянгол дүүргийн шуурхай штабын сахилга, зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэж буй байгууллага тус бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын уялдаа холбоо, дотоод хяналтыг сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Шуурхай штабын бүтэц

2.1.Шуурхай штаб нь тухайн өдрийн хуваарийн дагуу дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

Үүнд:

- 2.1.1.Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ажилтан (Штабын ахлах)
- 2.1.2.Дүүргийн Эрүүл мэндийн төвийн ажилтан (Штабын нарийн бичиг)
- 2.1.3.Дүүргийн цагдаагийн газрын ажилтан (штабын гишүүн)
- 2.1.4.Дүүргийн Мэргэжлийн хяналтын ажилтан (штабын гишүүн)
- 2.1.5.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан (штабын жолооч)

Гурав. Шуурхай штабын дотоод зохион байгуулалт

3.1.Дүүргийн Засаг даргын баталсан захирамж, хуваарийн дагуу холбогдох байгууллагын албан хаагчид шуурхай штабт 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.

3.2.Дүүргийн харьяа хэлтэс, албадаас шуурхай штабт томилогдсон албан хаагч тухайн өдөр үүрэг гүйцэтгэхдээ байгууллага дээрээ бусад өөр ажил үүргийг давхар гүйцэтгэхгүй байх.

3.3.Захирамжаар батлагдсан хуваарийг өөрчлөхгүй, зайлшгүй тохиолдолд урьдчилан 3 хоногийн өмнө Засаг даргын Тамгын газарт мэдэгдсэн байна.

3.4.Шуурхай штабд үүрэг гүйцэтгэх албан хаагчид 09:00 цагт ээлжийн үүргийг хүлээж авах ба бууж байгаа ээлжийн бүрэлдэхүүн дараагийн ээлжийг бүрэн ирсний дараа тухайн өдрийн үйл ажиллагаа цаашид анхаарах зүйлсийг танилцуулаад жижүүрээс бууна.

3.5.Өдрийн хоол 13:00, оройн хоол 19:00 цагт байна, унтлагын цагийг штабыг ахалж байгаа албан тушаалтан 23:00 цагаас 03:30, 03:30 цагаас 07:00 цагийн хооронд хэсэгчилсэн хуваарь гаргаж зохион байгуулна.

3.6. Штабын дарга нь сахилга, дэг журам, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулан, хяналт тавин ажиллана.

3.7. Онцгой байдлын хэлтсээс үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч нь өдөр тутмын мэдээг нэгтгэх ажлыг нарийн бичигтэй хамтран гүйцэтгэнэ.

3.8. Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Мэргэжлийн хяналтын хэлтсийн албан хаагчид хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээлэлтэй холбоотой асуудлыг шат дараалсан дарга нартаа уламжиллаж шийдвэрлүүлэх, дуудлага мэдээллийн дагуу газар дээр нь хүрэлцэн очиж шийдвэр гарган ажиллана.

#### Дөрөв. Штабын гүйцэтгэх үүрэг

4.1. Штаб нь нийслэлийн шуурхай штабтай холбогдож цаг үеийн мэдээлэл солилцоно.

4.2. Цаг үеийн холбогдолтой үүссэн нөхцөл байдлын мэдээллийг тухай бүрд Засаг даргын орлогч, Онцгой байдлын хэлтэст шуурхай мэдэгдэнэ.

4.3. Нийслэлийн шуурхай штаб болон хороод, байгууллага, иргэдээс ирүүлсэн чиг үүрэгт хамаарах дуудлага мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх.

4.4. Хоногийн мэдээ тайланг Онцгой байдлын хэлтсийн даргаар хянуулан дүүргийн Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагчид танилцуулна. Даваа гараг бүр ээлжнээс бууж байгаа хэлтэс, албаны дарга нар өмнөх 7 хоногийн мэдээг нэгтгэж дүүргийн Засаг даргад танилцуулж байх.